



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/352

Чингис хот

Б.Нямхатанг түр орлон гүйцэтгэгчээр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баттулгын Нямхатан нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, тус газрын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 05/8834 тоот албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Э.Мөнх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Л.Түмэнжаргал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч

3. Б.Нямхатанд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч /Л.Түмэнжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Нямхатанд үүрэг болгосугай.

5. Б.Нямхатанд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ